

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Аудитор: Ц.Уртнасан Утас: 7036-2442 Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН-  
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.БААСАНСҮРЭН ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/014/НА-СГА-ТМЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 295,609.0 мянган төгрөгийн сантехникийн их засвар хийгдсэнийг капиталжуулан бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд 5 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 95.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан***/төгрөгөөр/*

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	175,181,800.91	130,083,477.83
2	31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	95,881,959.73	43,354,023.38
3	31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	95,881,959.73	43,354,023.38
4	31210	Төгрөг	95,881,959.73	43,354,023.38
5	31211	Төрийн сангийн харилцах	95,881,959.73	43,354,023.38
6	33	АВЛАГА	1,188,539.33	284,252.6
7	33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,188,539.33	0.0
8	33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.0	284,252.6
9	35	БАРАА МАТЕРИАЛ	78,111,301.85	86,445,201.85
10	35400	Хангамжийн материал	78,111,301.85	86,445,201.85
11	35410	Бичиг хэргийн материал	1,384,787	3,156,387
12	35420	Аж ахуйн материал	61,375,759.85	67,938,059.85
13	35450	Барилгын засварын материал	2,876,000	2,876,000
14	35470	Бусад хангамжийн материал	12,474,755	12,474,755
15	2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	748,884,184.24	991,890,216.85
16	39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	748,884,184.24	991,890,216.85
17	39200	Биет хөрөнгө	739,572,184.08	982,578,216.85
18	39201	Барилга, байгууламж, орон сууц	719,306,305.06	1,014,915,343.06
19	39202	Хуримтлагдсан элэгдэл	-95,732,722.44	-116,178,788.68
20	39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	81,907,248	88,722,248
21	39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,722,303.64	-45,290,194.74
22	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,691,102.86	64,691,102.86
23	39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,544,918.76	-30,473,784.64
24	39209	Зам, гүүрийн байгууламж	1,084,000	1,084,000
25	39210	Хуримтлагдсан элэгдэл	-559,999.8	-821,999.84
26	39214	Бусад үндсэн хөрөнгө	13,234,713	13,234,713
27	39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,617,356.2	-7,830,538.17
28	39217	Ном	526,116	526,116
29	39300	Биет бус хөрөнгө	9,312,000.16	9,312,000
30	39301	Програм хангамж	250,000	250,000
31	39302	Хуримтлагдсан элэгдэл	-249,999.84	-250,000
32	39303	Бусад биет бус хөрөнгө	9,312,000	9,312,000
33	3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	924,065,985.15	1,121,973,694.68
34	4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,913,538.2	8,129,740

35	41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,913,538.2	8,129,740
36	41300	Өглөг	1,913,538.2	8,129,740
37	41310	Ажилчидтай холбогдсон өглөг	308,138.2	0.0
38	41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	439,500	6,963,640
39	41360	Бусад өглөг	1,165,900	1,166,100
40	41361	Байгууллагад төлөх өглөг	1,165,900	1,166,100
41	5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	922,152,446.95	1,113,843,954.68
42	51	Засгийн газрын хувь оролцоо	922,152,446.95	1,113,843,954.68
43	51100	Засгийн газрын оруулсан капитал	202,588,074.46	202,588,074.46
44	511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	202,588,074.46	202,588,074.46
45	51200	Хуримтлагдсан үр дүн	232,052,129.27	423,743,637
46	51210	Өмнөх үеийн үр дүн	222,128,819.25	231,808,129.27
47	51220	Тайлант үеийн үр дүн	9,923,310.02	191,935,507.73
48	51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	487,512,243.22	487,512,243.22
49	6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	924,065,985.15	1,121,973,694.68

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	947,307,471.52	1,391,009,538
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,873,071.52	1,391,009,538
3	120	Нийтлэг татварын бус орлого	107,873,071.52	320,831,838
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000	0
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000	0
6	120009	Бусад орлого	0.0	15,852,000
7	120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	67,112,311.58	295,609,038
8	120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	40,725,759.94	9,370,800
9	122	Тусламжийн орлого	0.0	1,070,177,700
10	1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,070,177,700
11	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,062,162,700
12	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	1,062,162,700
13	12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	8,015,000
14	122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	8,015,000
15	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	839,434,400	0.0

16	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	839,434,400	0.0
17	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	839,434,400	0.0
18	II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	915,544,161.66	1,199,074,030.27
19	21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,544,161.66	1,199,074,030.27
20	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	915,544,161.66	1,193,433,630.27
21	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,104,636.64	916,656,710.12
22	210101	Үндсэн цалин	449,483,479.49	564,140,757.14
23	210102	Нэмэгдэл	207,618,277.15	303,658,516.47
24	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	16,145,994.66
25	210104	Урамшуулал	26,002,880	32,711,441.85
26	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,042,434.44	107,592,085.68
27	210201	Тэтгэврийн даатгалын зардал	57,419,859.74	75,068,476.51
28	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	6,755,752.91	8,532,740.24
29	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,408,907.41	4,005,988
30	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,228,413.75	3,973,389.97
31	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	13,229,500.63	16,011,490.96
32	2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	516,450
33	210401	Бичиг хэрэг	0.0	296,450
34	210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.0	220,000
35	2105	Нормативт зардал	78,675,830	80,031,300
36	210502	Хоол, хүнс	78,675,830	80,031,300
37	2107	Томилолт, зочны зардал	0.0	80,000
38	210702	Дотоод албан томилолт	0.0	80,000
39	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,301,140	3,433,929.08
40	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,301,140	3,433,929.08
41	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,420,120.58	85,123,155.39
42	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,207,650	19,479,000
43	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,838,500	6,226,150
44	210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,373,970.58	59,418,005.39
45	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	5,640,400
46	2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	5,640,400
47	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	5,640,400
48	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,763,309.86	191,935,507.73
49	V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,839,999.84	0.0
50	225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	21,839,999.84	0.0
51	VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-21,839,999.84	0.0
52	VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	9,923,310.02	191,935,507.73

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	839,469,400	1,086,029,700
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000	1,086,029,700
3	120	Нийтлэг татварын бус орлого	35,000	23,867,000
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000	23,867,000
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000	23,867,000
6	122	Тусламжийн орлого	0.0	1,062,162,700
7	1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,062,162,700
8	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,062,162,700
9	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	1,062,162,700
10	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	839,434,400	0.0
11	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	839,434,400	0.0
12	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	839,434,400	0.0
13	II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	873,007,789.99	1,138,557,636.35
14	21	УРСГАЛ ЗАРДАЛ	873,007,789.99	1,138,557,636.35
15	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,007,789.99	1,132,917,236.35
16	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,311,386.17	916,070,147.27
17	210101	Үндсэн цалин	454,731,883.64	563,393,377.51
18	210102	Нэмэгдэл	203,642,119.93	303,658,516.47
19	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	16,145,994.66
20	210104	Урамшуулал	24,937,382.6	32,872,258.63
21	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,105,133.82	107,623,400
22	210201	Тэтгэврийн даатгалын зардал	57,326,523.33	73,178,200
23	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	6,755,752.91	8,613,900
24	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,408,907.4	4,308,400
25	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,267,237.43	4,308,400
26	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	13,346,712.75	17,214,500
27	2105	Нормативт зардал	78,629,830	73,067,660
28	210502	Хоол, хүнс	78,629,830	73,067,660
29	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	6,815,000
30	210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	6,815,000
31	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,301,140	3,433,929.08
32	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,301,140	3,433,929.08
33	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,660,300	25,907,100
34	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,182,000	19,383,950

35	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,478,300	6,523,150
36	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	5,640,400
37	2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	5,640,400
38	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	5,640,400
39	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-33,538,389.99	-52,527,936.35
40	VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-33,538,389.99	-52,527,936.35
41	101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,420,349.72	95,881,959.73
42	20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,881,959.73	43,354,023.38

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл				
			Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	211,208,819.33	901,309,137.01
2	2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	10,919,999.92	10,919,999.92
3	3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	222,128,819.25	912,229,136.93
4	9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	9,923,310.02	9,923,310.02
5	10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	232,052,129.27	922,152,446.95
6	11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	232,052,129.27	922,152,446.95
7	13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	232,052,129.27	922,152,446.95
8	16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	-244,000	-244,000
9	19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	191,935,507.73	191,935,507.73
10	20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	423,743,637	1,113,843,954.68

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Улсын төсөв

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,086,729,300	1,086,029,700	699,600	99.9
2	12	Татварын бус орлого	1,086,729,300	1,086,029,700	699,600	99.9
3	120	Нийтлэг татварын бус орлого	23,867,000	23,867,000	0	0
4	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	23,867,000	23,867,000	0	0
5	122	Тусламжийн орлого	1,062,862,300	1,062,162,700	699,600	99.9
6	122005	Төсвөөс санхүүжих	1,062,862,300	1,062,162,700	699,600	99.9
7	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,167,103,600	1,138,557,636.35	28,545,963.35	97.6
8	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,167,103,600	1,138,557,636.35	28,545,963.35	97.6
9	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,161,463,200	1,132,917,236.35	28,545,963.35	97.6
10	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	927,067,100	916,070,147.27	10,996,952.73	98.8
11	210101	Үндсэн цалин	595,762,700	563,393,377.51	32,369,322.49	94.6
12	210102	Нэмэгдэл	311,953,900	303,658,516.47	8,295,383.53	97.3
13	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	16,145,994.66	-16,145,994.66	100
14	210104	Урамшуулал	19,350,500	32,872,258.63	-13,521,758.63	169
15	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,185,100	107,623,400	7,561,700	93.4
16	210201	Тэтгэврийн даатгал	78,163,400	73,178,200	4,985,200	93.6
17	210202	Тэтгэмжийн даатгал	9,255,400	8,613,900	641,500	93.1
18	210203	ҮОМШӨ-ний даатгал	4,627,700	4,308,400	319,300	93.1
19	210204	Ажилгүйдлийн даатгал	4,627,700	4,308,400	319,300	93.1
20	210205	Эрүүл мэндийн даатгал	18,510,900	17,214,500	1,296,400	93.0
21	2105	Нормативт зардал	73,767,300	73,067,660	699,640	99.1
22	210502	Хоол, хүнс	73,767,300	73,067,660	699,640	99.1
23	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,015,000	6,815,000	1,200,000	85.0
24	210601	Багаж, техник, хэрэгсэл	8,015,000	6,815,000	1,200,000	85.0
25	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,840,100	3,433,929.08	406,170.92	89.4
26	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,840,100	3,433,929.08	406,170.92	89.4
27	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,588,600	25,907,100	7,681,500	77.1
28	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,017,600	19,383,950	7,681,500	77.1
29	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,571,000	6,523,150	47,850	99.3
30	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,640,400	5,640,400	0	100
31	2132	Бусад урсгал шилжүүлэг	5,640,400	5,640,400	0	100

32	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,640,400	5,640,400	0	100
33	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-80,374,300	-52,527,936.35	27,846,363.65	65.4
34	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,374,300	52,527,936.35	27,846,363.65	65.4
35	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	80,374,300	52,527,936.35	27,846,363.65	65.4
36	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	95,881,959.73		
37	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	43,354,023.38		

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Орон нутгийн төсөв

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
2	12	Татварын бус орлого	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
3	122	Тусламжийн орлого	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
4	122005	Төсвөөс санхүүжих	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
5	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
6	21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
7	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,254,100	72,892,180.15	4,361,919.85	94.3
8	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,838,100	66,476,180.15	4,361,919.85	94.3
9	210301	Гэрэл, цахилгаан	19,800,000	15,451,152.15	4,348,847.85	78.0
10	210302	Түлш, халаалт	48,635,100	48,635,028	72.00	99.9
11	210303	Цэвэр, бохир ус	2,403,000	2,390,000	13,000.00	99.4
12	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,416,000	6,416,000	0	100
13	210604	Урсгал засвар	6,416,000	6,416,000	0	100
14	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0	0		
15	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	0		
16	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0	0		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **10,305.4** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 7,257.0 төгрөгөөр илүү тайлагнасан,
- НДШ-ийн тайлгаар 284.2 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй
- Санхүүгийн тайланд цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын авлага тайлагнагдаагүй боловч татварын тайланд 2,764.2 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-12 “*Бараа материал*”-ийн 16<sup>1</sup>, УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн 13<sup>2</sup>, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын 3.4, 10.23, 10.26 дахь заалтууд болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 22,099.4 мянган төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс 2,660.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 19,439.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс бага 2,660.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 9,933.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.**

Commented [OA1]: Дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах

#### 3.2 Албан шаардлага

**3.2.1.** Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 284.2 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

<sup>1</sup> Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.

<sup>2</sup> Элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм, ашиглалтын хугацаа гэдэг нь а)байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа,

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.2.2.** Тус цэцэрлэгийн албан хаагчид нь зуны ээлжийн амралттай ажиллаагүй хугацаанд ёс зүйн дэд хорооны гишүүний урамшууллын 2,376.0 мянган төгрөгийг Д.Гантуяа, Б.Баасансүрэн, Б.Энхцэцэг нарт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10,2 дах “10.2.Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нормативт зардалтай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны хүнсний материалыг олгохдоо насны ялгавартай нормативын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 2 өдрийн А/166 / А/559/ 222 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тогтоосон тушаалыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хоолны хүнсний материалыг батлагдсан нормативын дагуу насны ялгавартайгаар тооцож олгох зөвлөмж хүргүүлээ.

#### **2. Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилахтай холбоотой асуудал:**

2.1 Илрүүлэлт: Тус цэцэрлэг нь хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилах ажлын хэсгийг байгуулаагүй бөгөөд батлагдсан заавар журмын дагуу ажиллаагүй байна.

Энэ нь Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар баталсан “Заавар шинэчилэн батлах тухай” тушаалын 1-р хавралтын 3.3. дах “Энэ зааврын 3.2-т заасан хуваарийн дагуу сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, мэргэжлийн багш нарын бүлгийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий таваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг цэцэрлэгийн эрхлэгч/сургуулийн захирлын тушаалаар томилон ажиллуулна” гэсэн заалтыг

зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, ажлын хэсгийг томилон зааврын дагуу ажилуулах зөвлөмж хүргүүлээ.

### **3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

**3.1 Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 19,439.2 мянган төгрөгийн анхны үнэтэй 156 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш жил тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” ХЗУ4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...” гэсэн заалтууд болон болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>4</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>4</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг илүү тайлагнасан	1	7,257.0			1	7,257.0	1	7,257.0				
НДШ-ийн тайлангаар авлагатай тайлагнагдсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй	1	284.2			1	284.2	1	284.2				
Санхүүгийн тайланд цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын авлага тайлагнагдаагүй боловч татварын тайланд авлага тайлагнагдсан	1	2,764.2			1	2,764.2	1	2,764.2				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>10,305.4</b>			<b>3</b>	<b>10,305.4</b>	<b>3</b>	<b>10,305.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлбөр тооцоог хянагуйн улмаас НДШ-ийн авлага үүсгэсэн.	1	284.2				284.2						
Ээлжийн амралттай байх хугацаанд ёс зүйн дэд хорооны гишүүний урамшуулал олгосон	1	2,376.0	1	2,376.0		0						
Хүүхдийн хоолны хүнсний материалыг нормативын дагуу насны ялгавартай тооцож олгоогүй	1						1	0				
Тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй.	1	19,439.2					1	19,439.2				
Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилах ажлын хэсгийг байгуулаагүй бөгөөд батлагдсан заавар журмын дагуу ажиллаагүй	1						1	0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>22,099.4</b>	<b>1</b>	<b>2,376.0</b>	<b>1</b>	<b>2,660.2</b>	<b>3</b>	<b>19,439.2</b>				



